

Сэлэнгэ аймаг



Сэлэнгэ аймагт МАСАМ II төслийг хэрэгжүүлэгч “Эерэг өөрчлөлтийг хамтдаа” болон “Сурагчийн хөтөч” ТББ-ууд тус аймгийн Нэгдсэн эмнэлгийн Нүдний кабинет, Боргүвээ 5 дугаар өрхийн эмнэлэг, тус багийн удирдлагатай хамтран Сүхбаатар сумын алслагдсан Боргүвээ 5 дугаар багийн 40 иргэнд **нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт** зохион байгууллаа. Энэ үйл ажиллагаа нь тус багийн өрхийн эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд зохион байгуулагдав. Сургалтад оролцогсод МАСАМ II төслийн талаарх танилцуулгатай танилцсаны дараа нүдний глауком өвчин, давсны хэрэглээний тухай өөрсдийн мэдлэгээ өргөжүүлэв. Сургалтын үеэр сургалтад оролцогсдын нүдний уг харах, хараа оношлох, даралт болон сахар үзэх үйлчилгээг хүргэв. Мөн сургалтанд хамрагдсан иргэд ӨЭМТ-ийн чанар хүртээмжийг сайжруулах талаарх санал сэтгэгдэлээ хуваалцав.



Дундговь аймаг



Японы Хүүхдийг Ивээх Сангийн хариуцан ажиллаж буй Зүүн болон говийн бүсийн аймгуудын орон нутагт ажиллах ТББ-ууд нийгмийн эгэх хариуцлагын санал санаачлагыг мөн орон нутаг бүртээ өрнүүлж эхлээд байна. Тус санаачлагын хүрээнд Дундговь аймагт сонгогдсон “Говийн Хөгжил Наран” НҮТББ нь тус аймгийн Сайнцагаан сумын “Өлзийт мандал ӨЭМТ-ийн нийгмийн эгэх хариуцлага, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх нь” дэд төсөл хэрэгжүүлж эхэллээ. Уг төслийг “Говийн хөгжил наран” ТББ, “Сургалт судалгааны хүрээлэн” ТББ, Өлзийт мандал ӨЭМТ хамтран хэрэгжүүлж байгаа ба төслөөр **“Иргэдийн оролцооны баг”** байгуулж, чадавхжуулан, чадавхижсан иргэдийн тусламжтайгаар эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авахад нь тулгамдаж байгаа асуудлуудыг судалгааны арга ашиглан тодорхойлж, иргэдийн оролцоотойгоор эрэмбэлэн, нөлөөллийн ажил зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. 3 дугаар сарын эхний долоо хоногт тус төслийн багаас хамтран ажиллах иргэдийг сонгон, анхны уулзалтаа хийсний үр дүнд **“Иргэдийн оролцооны баг”** байгуулсан байна. Цаашид **“Иргэдийн оролцооны баг”**-ийн оролцоотойгоор **300** иргэнээс судалгаа авах ажлыг хийхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

Булган аймаг



Булган аймагт МАСАМ II төслийг хэрэгжүүлэгч төслийн баг болон ЛЭОС Булган салбар, “Буйлхан ногоон хөгжил” ТББ-уудын төлөөлөөс бүрдсэн ажлын хэсгийн гишүүд **төр-ИНБ-ын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр** тус аймгийн ИНБ-ууд болон Булган сумын удирдлагуудтай 2022 оны 3 дугаар сард уулзалт хийж, энэ онд хийх ажлын төлөвлөгөөг гаргалаа. Төлөвлөгөөний дагуу хэд хэдэн үйл ажиллагааг хоёр зорилгын хүрээнд хийнэ.



Тухайлбал, нэгдүгээрт, ӨЭМТ-ийн чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр гадаад, дотоод орчны баримт бичгийн судалгаа, үнэлгээг хийх, үнэлгээг хийхдээ бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаар авах бөгөөд ганцаарчилсан ярилцлага хийгдэж эхэлжээ. Түүнчлэн, хэрэглэгчдийн судалгааг Хэрэглэгчийн үнэлгээний карт аргачлалаар авна. Хоёрдугаарт, Булган, Бугат, Орхон сумдын төсөвт хяналт тавих зорилгоор **“Иргэдийн хяналтын бүлэг”** байгуулна. **“Иргэдийн хяналтын бүлэг”** байгуулахад, багийн ЗД-тай хамтран иргэдийг сонгон, сургалт мэдээлэл өгч чадавхжуулна.

Ховд аймаг



Ховд аймгийн “Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ-ын үйл ажиллагааг онцолж байна. “Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ нь “Төсвийн хөрөнгө оруулалтад эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт сургалтыг аймгийнхаа ЗДТГ, Эмэгтэйчүүдийн холбоо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Дэлхийн Зөн Ховд” орон нутгийн хөтөлбөртэй хамтран 3 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулжээ. Энэ удаагийн сургалтад Жаргалант сумын 12 багийн эмэгтэйчүүдийн төлөөлөл нийт 125 хүн оролцов. Сургалтыг үндсэн 3 зорилготой зохион байгуулжээ. Нэгдүгээрт, **эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх**, тэдний дуу хоолойг сонсох байсан бол хоёрдугаарт, төсвийн хөрөнгө оруулалтад эмэгтэйчүүдийн манлайллыг бий болгох байв. Харин гуравдугаарт, **эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, жендэрийн тухай ойлголтыг сайжруулахад** чиглэлээ. Оролцогчдод төслийн зүгээс боловсруулсан 4 модуль хичээлийн эхний 2 модулийг заасан юм. Сургалтын үр дүнд цаашид төсөв, иргэдийн оролцооны чиглэлээр ажиллах сонирхолтой, идэвхитэй 20 эмэгтэйг сонгон чадавхжуулах, орон нутагт төсөв дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нөлөөллийн ажлыг эхлүүлэхээр боллоо.

Орхон аймаг



Орхон аймагт МАСАМ II төслийг хэрэгжүүлэгч “Эрдэнэт хүмүүний эв нэгдэг” ТББ, “Онч зөв сэтгэл” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвөөс үндсэн хоёр чиглэлээр үйл ажиллагааг явуулж эхэллээ. Тухайлбал, тус аймгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгын хүрээнд Орхон аймагт үйл ажиллагаагаа явуулдаг **найман ӨЭМТ-д гадаад, дотоод орчны үнэлгээ хийж эхэллээ.**

Тус үнэлгээний үр дүнг урьдчилсан байдлаар багцалбал, гадна орчны үнэлгээнээс үзэхэд өрхийн эмнэлгүүдийн барилга нь 2017 онд ашиглалтанд орсон боловч бичиг баримтгүй байна. Ашиглалтад орсноос хойш 2-3 удаа “Анхны оч” эмнэлгийн орох хаалганы шатны довжоонууд доошоо цөмөрч орсныг, өөрсдийн хөрөнгөөр зассан, гадна машины зогсоолгүй тул дэргэдэх ЕБС-ийн гадна талбайн зогсоолыг ашигласан байдалтай байгаа аж. Түүнчлэн, тэргэнцэртэй иргэдэд зориулсан замтай ч хэт огцом, цемент цутгаж хийгдсэн тул хагарч, том том ан цав гарсан тул тэргэнцэртэй хүн явахад хүндрэлтэй, өвлийн улиралд гулгаа үүсдэг шинжтэй. Тус ӨЭМТ-үүдийн шилэн дансны цахим болон мэдээллийн самбарын **ил тод байдлын тухайд хуулийн хэрэгжилт хангалтгүй**, эмнэлгийн цахим хуудастай ч иргэд түгээх ажил хангалтгүй байна.

Багануур дүүрэг



Багануур аймагт МАСАМ II төслийг хэрэгжүүлэгч “Багануур Азийн Нөхөрлөл” болон ЭТББ-ын МАСАМ II төслийн баг тус төсөл хэрэгжих 1 дүгээр хорооны ажлын алба, Энэрэлт-Өлзий ӨЭМТ-ийн удирдлага, ажилтнууд нийт 20 хүнтэй 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдөр уулзаж, МАСАМ II төслийн талаарх мэдээлэл хүргэж, тус төслийн хүрээнд хийгдэх ажлуудыг танилцуулж, **үнэлгээ хийх үйл явцад иргэдийн оролцоог сайтар хангах**, төслийн мэдээ мэдээллийг иргэдэд идэвхтэй хүргэх гэх мэт ажлыг харилцан тохирчээ.

“Багануур Азийн Нөхөрлөл” ТББ-ын МАСАМ II төслийн баг ӨЭМТ-ийн гадаад, дотоод орчны үнэлгээг **гурван өөр өнцгөөс** хийж байна. Тухайлбал, төслийн баг Глоб Интернэшл төвөөс бэлтгэсэн маягтын дагуу өөрсдөө үнэлсэн бол ӨЭМТ-ийнхээ удирдлага, ажилтнууд бүрээр мөн үнэлүүлжээ. Гурав дахь үнэлэгч тал нь иргэд байх бөгөөд нийт 100 иргэнээр үнэлүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна.



МЕНТОРИНГ

ОРОН НУТГИЙН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МЕНТОРИНГ

Ц.ГАНЦЭЦЭГ
ЛЕОС Булган салбар

Б.ЛХАГВАА,
"Хөвсгөлийн хөгжил дэвшилд" ТББ

С.ЦЭРЭНПҮРЭВ,
"Захиргааны шинэ санаачлага" ТББ

3 ДУГААР САРЫН 16

тавьсан, зардлын зүйл ангийн нэр байгаа бүрэн мэдээллээгүй байдалтай байна. Сэлэнгэ аймгийн тухайд, төсөв гүйцэтгэлийн дүнг Хөрөнгө оруулалт, тендэр худалдан авалт цэсэнд байрлуулсан. Налайх, Багануур, Сонгинохайрхан дүүргүүдийн ӨЭМТ-үүдийн хувьд 2022 оны 1, 2 сард огт мэдээлэл оруулаагүй, 2021 оны зөвхөн төсөв, гүйцэтгэлийг улирлаар байршуулсан байдалтай байна.

Тэрбээр хуулийн хүрээнд ӨЭМТ-үүдээс яагаад төсвийн ил тод байдлаа хангахгүй байгаа шалтгааныг тодруулах зорилгоор шаардлага тавих, аймаг, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүсэлт гаргах, Санхүү, дотоод аудитын албанд мэдээлэх, Төрийн аудитад хүсэлт гаргах, Монгол Улсын Сангийн яаманд мэдээлэл хүргүүлэх гэх зэошээр хуулийн хэрэгжилтийг хангуулахад төсөл хэрэгжүүлэгчид анхаарах, үүнд хүчээ нэгтгэхийг уриалав.

"Захиргааны шинэ санаачлага" ТББ-ын тэргүүн С.Цэрэнпүрэв **"Тендэрт хэрхэн хяналт тавих вэ?"** сэдвийн хүрээнд төрийн худалдан авалтад оролцох, хяналт тавих хууль эрх зүйн заалтуудын хүрээнд хэрхэн үр дүнтэй оролцох талаар туршлагаа хуваалцсан бол, иргэдийн хяналтын бүлгийг байгуулах 3 үе шат болоод баримтлах 10 зарчмыг дэлгэрэнгүй тайлбарлаж, харилцан ярилцав. Булган дахь ЛЭОС-ын салбарын гишүүн Ц.Ганцэцэг **"Судалгааны арга зүй"** сэдвийн хүрээнд хэрэглэгчийн үнэлгээний судалгааны ач холбогдол, бүрэлдэхүүн хэсэг болон хамрах хүрээний талаар дэлгэрэнгүй менторлохын зэрэгцээ Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгт хийсэн судалгааны үр дүнг танилцуулах замаар судалгаанд юуг анхаарах, судалгааны үр дүнд нөлөөлж болохуйц эерэг, сөрөг хүчин зүйлсийн талаар ярилцаж менторлов.

МАСАМ II төслийн хүрээнд 10 орон нутагт буюу 7 аймаг, 3 дүүрэгт энэхүү төслийг хэрэгжүүлэх орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудыг менторлох үйл ажиллагаа 3 дугаар сарын 16-наас амжилттай эхэллээ.

"Хөвсгөлийн хөгжил, дэвшилд" ТББ-ын тэргүүн Б.Лхагваа **"Эрүүл мэндийн салбарын төсвийн ил тод байдалд үнэлгээ хийх нь"** сэдвийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн төсвийн ил тод байдлын өнөөгийн нөхцөл байдал ямар байх ёстой ямар байгааг хууль эрх зүйн тодорхой заалтуудын хүрээнд тайлбарлав. Тухайлбал, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 12.1.3-12.1.6, Шилэн дансны тухай хуулийн 2.1, 3.1, 3.1.5 болон шилэн дансны зарчмуудын дагуу хэрхэн ӨЭМТ-ийн төсвийн ил тод байдалд shilendans.gov.mn цахим хуудсанд мониторинг хийх талаар зааж менторлов.

Өнөөдрийн байдлаар ӨЭМТ-үүдийн цахим мэдээллийн ил тод байдал ямар байна вэ? "Хөвсгөлийн хөгжил, дэвшилд" ТББ-ын тэргүүн Б.Лхагваагийн ажигласнаар, Булган, Орхон, Дархан аймгийн ӨЭМТ-үүдийн нэрс shilendans.gov.mn цахим хуудаст огт байхгүй байна. Төв аймгийн "Баруун зуун мод" ӨЭМТ-ийн 2022 оны 1, 2 дугаар сарын мэдээлэл зөвхөн төсөв, гүйцэтгэл

05 ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ



СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ИНДЕКСИЙН УТГА

- 4.00 – 5.00 Хэрэглэгч сэтгэл ханамж маш өндөртэй, хэрэглэгчтэй холбоотой үзүүлэлтүүдийг энэ хэвээр нь хадгалах шаардлагатай;
- 3.00 – 3.99 Хэрэглэгч сэтгэл ханамжтай, гэхдээ хэрэглэгчтэй холбоотой зарим үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай;
- 2.00 – 2.99 Хэрэглэгч сэтгэл ханамж муутай, хэрэглэгчтэй холбоотой нэлээд олон үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай;
- Хэрэглэгч огтхон ч сэтгэл ханамжгүй, цаашид хэрэглэгчтэй холбогдож байгаа буюу л эхэсг дээр анхаарч ажиллах шаардлагатай
- > 1.99

- Сэтгэл ханамжийн үнэлгээг олон улсын хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хэмжих гол үзүүлэлт болох СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ИНДЕКС - ээр хэмждэг.
- Энэхүү шинжилгээнд тодорхой шатлал бүхий хэмжүүрийг ашигладаг бөгөөд анх Ринсис Лайкерт 1932 онд боловсруулан гаргасан ба өнөөг хүртэл олон улсад өргөн ашиглагдаж байна.
- Лайкертын хэмжүүр нь ихэвчлэн ажилчид болон хэрэглэгчдийн дунд хийгддэг судалгааны хүрээнд ашиглагдаж сэтгэлзүйг хэмжих үндсэн үзүүлэлт болдог.

Баг, хороонд Иргэдийн хяналтын бүлэг байгуулах

Нэг. Бэлтгэл үе шат

Хоёр. Иргэдийн хяналтын бүлгийг байгуулах үе шат

Гурав. Хяналтын бүлгийн гишүүдийг чадваржуулах үе шат

“ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫН ОЙЛГОЛТ, АРГА ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТЫН ЭРГЭН ТОЙРОНД



МАСАМ II төслийн үндэсний түвшинд хэрэгжүүлэгч Глоб Интернэшнл төв ТББ, Дэлхийн Зөн Монгол ОУБ болон Японы Хүүхдийг ивээх сан 21 аймаг, 9 дүүргийн төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын болон иргэдийн төлөөллийг чадавхжуулах 4 модуль бүхий “Төсвийн үйл явцад нийгмийн эгэх хариуцлагын ойлголт, арга хэрэгслийг ашиглах нь” сэдэвт сургалтыг 2021 оны 11 сараас 2022 оны 3 сарын 29 хүртэл амжилттай зохион байгуулж дууслаа. Сургалтад нийт **1186** хүн хамрагдсанаас төрийн бус байгууллагын төлөөлөл **786**, төрийн байгууллагын төлөөлөл **400** хүн хамрагдав. Сургалтаар оролцогчдод нийгмийн эгэх хариуцлага, иргэдийн оролцоо, ил тод байдал, төрийн санхүүгийн удирдлага, улсын

төсөв, төсвийн харилцаа, улсын төсвийн хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тогтолцоо, стандарт, санхүүжилт болон эдгээрт иргэд хэрхэн оролцох арга зам зэрэг цогц мэдлэгийг олголоо.

Сургалтанд хамрагдсан зарим орон нутгийн ИНБ-уудын төлөөлөл орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөлтэй хамтран ажлын хэсэг байгуулж, төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулахад **иргэд, ИНБ-ын оролцоог нэмэгдүүлэх** болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр **нийгмийн эгэх хариуцлагын санал санаачлага** гарган өөрийн аймаг, дүүрэгтэй хамтран ажиллахаар боллоо.

Сургалт тооны хэлээр:

.....

Дэлхийн Зөн Монгол ОУБ - 17 удаагийн сургалт, нийт **497** хүн.
281 - иргэд, ИНБ-ын төлөөлөл,
216 - төрийн байгууллагын төлөөлөл.

.....

Глоб Интернэшнл төв ТББ - 15 удаагийн сургалт, нийт **406** хүн.
307 иргэд, ИНБ-ын төлөөлөл,
99 - төрийн байгууллагын төлөөлөл.

.....

Японы Хүүхдийг Ивээх сан ОУБ - 13 удаагийн сургалт нийт **283** хүн.
198 - иргэд, ИНБ-ын төлөөлөл,
85 - төрийн байгууллагын төлөөлөл.



ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТЭМДЭГЛЭЛ

Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын зорилтот орон нутгийн төлөөлөл



Завхан аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн **С.САРАНТУЯА**

Энэ удаагийн сургалт амьдралд ойрхон, энгийн үг хэллэгээр төсөв, төсвийн хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн салбарын тогтолцоо, санхүүжилтийг оролцогчдод **ойлгомжтой, дэс дараатай хүргэж, шинэлэг мэдээллээр баялаг** байгаа нь онцлог байлаа. Завхан аймгийн хувьд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах, эмч ажилчдыг чадавхжуулах, иргэдийг мэдээллээр хангах нь нэн тэргүүний чухал асуудлууд байгаа бөгөөд энэ чиглэлд төсөл хэрэгжиж буй нь олзуурхуштай байна.



Ховд аймгийн Жаргалант сумын 2-р багийн иргэн **Б.СУХБААТАР**


МАСАМ төслийн эхний үе шатанд оролцож байсан хүний хувьд сайн засаглал болон нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэхэд ИНБ-уудын оролцоо маш чухал гэдгийг сайтар ойлгосон. ИНБ-ууд хувийн эрх ашгаа нэгдүгээрт тавьж байгаа учраас сайн засаглал бэхжихэд бас саад тотгор болж байна. Иргэн хүний хувьд, би өөрийн чадлын хэрээр ИНХ болон **төсөв, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд саналаа илэрхийлж оролцох, цаашлаад үр хүүхдүүд, эргэн тойрныхондоо оролцохыг** уриална. Эцэст нь, мэдлэг мэдээлэлтэй, оролцоотой иргэн Монголын баялаг юм.



Завхан аймгийн Ахмад мэргэжилтний холбоо НҮТББ-ын гишүүн **Д.ЦЭВЭЛМАА**

Манай Ахмад мэргэжилтний холбоо ТББ нь МАСАМ II төслийн хүрээнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах зорилгын дор орон нутгийн ӨЭМТ, ЭМГ-тай хамтран ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд ТББ-ын хувьд эрүүл мэндийн салбарт ажиллах боломж бий болж байгаад маш их баярлаж байна. **Хамтын ажиллагааны үр дүнд сайн туршлагуудыг бий болгож чадна** гэж итгэж байна”.

Хүүхдийг ивээх сангийн зорилтот орон нутгийн төлөөлөл



Дундговь аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн дарга **Л.ШИРЧИНСҮРЭН**

Төрийн албан хаагчид бид өөрсдөө бас иргэд. Төрийн байгууллагууд иргэдтэйгээ үр дүнтэйгээр хамтран ажиллаж, ил тод нээлттэй байх ёстойг сайтар ойлгож авлаа. Төр хэдийгээр нээлттэй, ил тод байхыг хичээж, маш олон ажлыг хийж байгаа боловч **мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хүргэх тал дээр түлхүү ажиллах** хэрэгтэйг харлаа.



“Хараа хүрэхүй” НҮТББ-ын тэргүүн **Ц.СОЁЛ**

“Бид Монгол улсын төсвийн бүрдэлт, түүний зарцуулалтад иргэд, ИНБ-ууд хяналт тавих, амьдарч буй орчин, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр асуудлыг тодорхойлох, эрэмбэлэх, олон нийтийн эрх ашигт нийцсэн үйлчилгээг анхан шатны байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэх талаар суралцлаа. Нөгөөтэйгүүр, иргэд бид төсөв, түүний зарцуулалт, шилэн данс, ил тод гэж ямар мэдээллийг хэлэх, бид өөрсдөө **иргэний оролцоотой төртэйгөө** яаж хамтран ажиллах талаар мэдлэг, мэдээлэл маш тааруу байгааг олж харлаа.”



Өмнөговь аймгийн өндөр настан **Б.ЗАНДРАА**

“Бүх насны иргэдийн төлөөллийг оролцуулсан сайхан сургалт боллоо. Иргэд идэвхтэй оролцож, нийгмийн эгэх хариуцлага хөгжих боломжтой гэдгийг их сайн ойлголоо. Мөн улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтын талаар зүйлийг олж мэдлээ. Төсвийн талаар мэддэг ч энэ сургалтад оролцсоноор **мэдлэг маань их цэгцтэй, системтэй** боллоо. Ялангуяа төсвийн цаглабарын аль шатанд иргэд оролцож саналаа өгөх, саналаа өгөөд орхих биш, хяналт тавьж оролцох хэрэгтэйг ойлголоо”.

Глоб Интернэшнл төвийн зорилтот орон нутгийн төлөөлөл



Төв аймгийн Эрүүл мэндийн газрын /ЭМГ/ Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга **Б.ЭНХТУЯА**



Орхон аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн эдийн засагч **Г.БОЛДБААТАР**

“Энэ сургалтанд хамрагдсанаар аймгийнхаа ЭМГ-ын цахим хуудасны хөгжүүлэлтээ улам боловсронгуй болгоё гэсэн сэдэл төрлөө. Тухайлбал, ЭМГ-ын цахим хуудсаа бүх 27 сумын эрүүл мэндийн төв, нэг өрхийн ЭМТ-тэйгээ холбох ажлыг нэн тэргүүнд хийнэ. Яагаад гэвэл, мэдээллийн ил тод байдал, мэдээллийн урсгал гэдэг маш чухал юм байна. Тиймээс, **мэдээллийн урсгалыг маш чанартай, төгс болгоё** гэсэн бодолтой байна.”

Төр-иргэн хоёрын түншлэлийг бэхжүүлэхэд нийгмийн эгэх хариуцлага чухал нөлөөтэй юм байна. Сургалт, хэлэлцүүлэгт төрийн байгууллагын албан хаагчид, ИНБ-ууд, ӨЭМТ-ийн удирдлагууд, иргэд идэвхтэй оролцож байгааг хархад ихэд өргөн хүрээтэй боллоо. Хамгийн гол нь, сургалтаар иргэд маань төсвийн төлөвлөлт, төсвийн үр ашиг, иргэд яаж хяналт тавих, хяналт тавихын тулд хэрхэн оролцох, **иргэдийн эрх, үүрэг зэргийг тодорхой, ойлгомжтой хэлбэрээр тайлбарласан** сургалт боллоо.”




Булган аймаг дахь ЛЭОС ТББ-ын тэргүүн **Д.ЧИМГЭЭ**

“Төсвийн ил тод байдлыг цаашид хэрхэн сайжруулах, өмнө нь бидний хийж байсан ажлын ололт амжилт юу байв гэдгийг дүгнэх, тал дээр Глоб

Интернэшнл Төв ТББ-ын явуулсан энэ 3 хоногийн сургалт, хэлэлцүүлэг их өгөөжтэй, үнэ цэнэтэй байлаа. Сургалтаас олсон мэдлэг дээрээ түшиглээд, иргэд, ИНБ-ууд, төрийн байгууллагууд хамтарч ажиллах төлөвлөгөө гаргахаар шийдлээ. Сүүлийн жилүүдэд орон нутагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд нэмэгдэж байгаа ч үүнийг зориулалтын дагуу зарцуулах, хэрэгцээн дээр үндэслэн төлөвлөлт хийх, улсын төсвийг илүү үр ашигтай зарцуулах чиглэлд зайлшгүй тухайн орон нутгийн

иргэдийн санал санаачлага чухал юм. Орон нутгийн иргэдэд тодорхой эрх мэдэл өгөх, хөрөнгийн зарцуулалтад тэднийг оролцуулах шаардлага байгаа юм. Улсын төсвийн хөрөнгө оруулалт зураг төсөвгүй, тухайн орон нутгийн иргэдийн санал бодлыг сонсолгүйгээр, үрэлгэн байдлаар УИХ-ын танхимд шийдэгдэж байгаа нь учир дутагдалтай юм. **Энэ төсөл улсын төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөхөд нөлөөлнө** гэдэгт итгэлтэй байгаа.”



**“НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГА”
НҮҮР НОМЫН ХУУДАСТ ЛАЙК ДАРЖ
БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ!**



Like & Share

**ТӨЛӨВЛӨГӨӨТ ҮЙЛ
АЖИЛЛАГАА**

- ✓ АЙМГУУДЫН “ИРГЭДИЙН ТӨСӨВ”
- ✓ ИНБ-УУДЫГ ЧИГЛҮҮЛЭН ЗӨВЛӨХ БУЮУ МЕНТОРЛОХ
- ✓ ИНБ-УУДЫН ОРОЛЦООТ ТӨСВИЙН МОНИТОРИНГ ХИЙХ
- ✓ ИНБ-УУДЫН ТУРШЛАГА ХУВААЛЦАХ ФОРУМ ЗОХИОН БАЙГУУЛАХ
- ✓ ТӨСЛИЙН ЦАХИМ ХУУДАС ХӨГЖҮҮЛЭХ
- ✓ ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ
- ✓ ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙГ ТӨРӨЛ БҮРИЙН СУВГААР ДАМЖУУЛАХ
- ✓ ОЛОН ТАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛЭХ